


Хүйтний улирал буюу 2012-2015 оны 1-4, 10-12 дугаар сарын
Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдал
/2015 оны 10-12 дугаар сар/

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), том ширхэглэгт тоосонцор (PM_{10}), нарийн ширхэглэгт тоосонцор ($\text{PM}_{2.5}$), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат болон автомат бус багажаар хэмжин тодорхойлж байна.

2015-2016 оны хүйтний улирлын эхний саруудад буюу 2015 оны 10-12 дугаар сард агаар дахь агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2014 оны мөн үетэй харьцуулахад том ширхэглэгт тоосонцор **73 мкг-аар буюу 34%-иар**, нарийн ширхэглэгт тоосонцор **14 мкг-аар буюу 15%-иар**, азотын давхар исэл **2 мкг-аар буюу 6%-иар** тус тус бага, хүхэрлэг хийн агууламж **14 мкг-аар буюу 54%-иар** их байна.

2012-2015 оны хүйтний улирал (1-4, 10-12 дугаар сар)-ын Улаанбаатар хотын агаарын чанарын төлвийг агаар бохирдуулах бодис тус бүрээр дараах зургуудад харууллаа.

Том ширхэглэгт тоосонцор (PM_{10})




Зураг 1. Хүйтний улирлын том ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2015 он

Улаанбаатар хотын 2015 оны 10-12 дугаар сарын агаар дахь том ширхэглэгт тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 дугаар сард 32%-иар, 11 дүгээр сард 43%-иар, 12 дугаар сард 27%-иар тус тус бага байна. Харин сарын дундаж агууламжийг Агаарын чанарын стандарт дахь Хүлцэх хэм хэмжээ /цаашид АЧС дахь ХХХ гэх/-тэй харьцуулахад 10, 11 дүгээр сард 1.2-1.3 дахин, 12 дугаар сард 1.7 дахин их байна (Зураг 1).

Том ширхэглэгт тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2015 оны 10 дугаар сард нийт 177 удаа хэмжснээс 59%, 11 дүгээр сард нийт 141 удаа хэмжилт хийснээс 71%, 12 дугаар сард нийт 196 удаа хэмжснээс 63% нь АЧС дахь ХХХ-ээс давжээ.

2015 оны 10-12 дугаар сард 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 100 айл орчимд 940 мкг/м³ хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 9.4 дахин их, өмнөх оны мөн үед ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.1 дахин их байна.

Нарийн ширхэглэгт тоосонцор (PM2.5)




Зураг 2. Хүйтний улирлын нарийн ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2015 он

Агаар дахь нарийн ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж 2015 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9%-иар, 11 дүгээр сард 6%-иар, 12 дугаар сард 20%-иар тус тус бага байна. Нарийн ширхэглэгт тоосонцрын агууламж 2015 оны 10 дугаар сард АЧС дахь ХХХ-ны түвшинд байсан бол 11 дүгээр сард 1.7 дахин их, 12 дугаар сард 2.3 дахин их байна (Зураг 2).

Нарийн ширхэглэгт тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2015 оны 10 дугаар сард нийт 60 удаа хэмжсэнээс 48%, 11 дүгээр сард нийт 59 удаа хэмжсэнээс 81%, 12 дугаар сард нийт 58 удаа хэмжилт хийсэнээс 86% нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

Хүйтний улирлын 2015 оны 10-12 дугаар сарын 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 13-р хороолол орчим 284 мкг/м³ хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 5.7 дахин их, өмнөх оны мөн үед ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.2 дахин бага байна.

Азотын давхар исэл (NO_2)




Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2012-2015 он

Агаар дахь азотын давхар ислийн 2015 оны 10, 11 дүгээр сарын дундаж агууламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад тус бүр 9-11%-иар бага ба АЧС дахь ХХХ-ээс хэтрээгүй байна. Харин 12 дугаар сарын дундаж агууламж өмнөх оны түвшнээс өөрчлөгдөөгүй ч АЧС дахь ХХХ-ээс 1.2 дахин их байна (Зураг 3).

Азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламжийг 2015 оны 10 дугаар сард нийт 200 удаа хэмжилт хийснээс 39%-д, 11 дүгээр сард нийт 177 удаа хэмжилт хийснээс 55%-д, 12 дугаар сард нийт 194 удаа хэмжснээс 63%-д нь АЧС дахь ХХХ-ээс давжээ.

2015 оны 10-12 дугаар сарын 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 13-р хороолол орчимд 124 мкг/м^3 хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 3.1 дахин их, өмнөх оны мөн үед ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 1.1 дахин бага байна.

Хүхэрлэг хий (SO_2)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2012-2015 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2015 оны 10 дугаар сарын дундаж агууламж өмнөх оны мөн үеээс 5 мкг-аар их хэдий ч АЧС дахь ХХХ-ээс 2 дахин бага байна. Харин хүхэрлэг хийн 11 дүгээр сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе болон АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад тус бүр 2.3 дахин их, 12 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 дахин их, АЧС дахь ХХХ-ээс 3.2 дахин их байна (Зураг 4).

Хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламжийг 2015 оны 10 дугаар сард нийт 220 удаа хэмжилт хийснээс 17%, 11 дүгээр сард нийт 186 удаа хэмжилт хийснээс 85%, 12 дугаар сард нийт 224 удаа хэмжснээс 90% нь АЧС дахь ХХХ-ээс давсан тохиолдол ажиглагджээ.

2015 оны 10-12 дугаар сард 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 100 айл орчимд 293 мкг/м^3 хүрч АЧС дахь ХХХ-тэй харьцуулахад 14.6 дахин, өмнөх оны мөн үед ажиглагдсан 24 цагийн дунджийн хамгийн их агууламжтай харьцуулахад 2.1 дахин тус тус их байна.

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС